



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.06.17-06.21

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Ус, дулаан, цахилгаан хангамжийн компаниудын хувьцаа өссөн үзүүлэлттэй байв.

Холбооны Нөөцийн банк 2008 оноос хойш анх удаа бодлогын хүүгээ бууруулахад бэлэн гэсэн дохиог зах зээлд өглөө. Энэ оны сүүлчээр Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ бууруулж магадгүй гэсэн хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд үүсээд байсан билээ. Тэгвэл энэ долоо хоногт Холбооны нөөцийн сан эдийн засгийн өсөлтийг хадгалах зорилгоор шаардлагатай үед бодлогын хүүг бууруулна хэмээн мэдэгдэж, хөрөнгө оруулагчдын хүлээлтийг баталсан байна. АНУ-ын Төв банкны бодлогын зөвлөл энэ сарын 18-19-нд хуралдаж, бодлогын хүүг 2.25-2.5 хувьд хэвээр үлдээсэн юм. Ингэснээр 10 жилийн хугацаатай АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж буурчээ.

АНУ, Ойрх Дорнод хоорондын геополитикийн нөхцөл байдал муудаж, газрын тосны үнэ огцом өслөө. Персийн буланд газрын тосны хоёр хөлөг халдлагад өртсөнөөс үүдэн АНУ, Иран хоорондын харилцаа хурцадмал байдалд ороод байгаа юм. Мөн Даваа гарагт Иран улс 2015 оны цөмийн хэлэлцээрээс татгалзаж байгаагаа мэдэгдсэн билээ.

АНУ БНХАУ-ын 250 тэрбум ам.долларын импортод 25 хувийн тариф ногдуулаад байгаа юм. Харин үүнтэй холбоотойгоор "Walmart", "Target" тэргүүтэй 600 орчим АНУ-ын компаниуд БНХАУ-ын импортод ногдуулсан тарифыг цуцлахыг Засгийн газартаа уриалжээ.

Европ: Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Европын Төв банкны Ерөнхийлөгч Марио Драги АНУ-ын Холбооны нөөцийн сангийн адил эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор нэмэлт арга хэмжээ авч магадгүй талаар мэдээлэв. Евро бүсийн мөнгөний зах зээлийг зохицуулах үүднээс Европын төв банк 12-р сар гэхэд бодлогын хүүг 10 суурь нэгжээр бууруулж магадгүй гэж шинжээчид таамаглаж байна. Ингэснээр еврогийн ханш ам.долларын эсрэг 1 хувиар суларчээ.

Английн төв банк богино хугацаат бодлогын хүүгээ 0.75 хувьд үлдээхээр шийдвэрлэснээр фүнтийн ханш ам.долларын эсрэг 1 хувиар чангарав.

Их Британийн дараагийн Ерөнхий сайдыг сонгох Парламентын хоёр дахь санал хураалтад Борис Жонсон ялалт байгууллаа. Консерватив намаас Парламентад суугаа 313 гишүүний 126 нь Борис Жонсонд саналаа өгсөн байна. Тэрбээр энэ сарын эхээр болсон эхний санал хураалтад ч мөн тэргүүлсэн юм. Борис Жонсон Консерватив намыг тэргүүлж, Ерөнхий сайд болоход ийнхүү нэг алхам ойртож байна.

Япон: Японы төв банк бодлогын хүүндээ өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэв. Япон улсын Сангийн яамны мэдээлснээр 5-р сард тус улсын экспортын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувиар буурчээ. Үүнээс, БНХАУ руу гаргасан экспортын хэмжээ хамгийн ихээр буюу 10 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: Troweprice.com, BloombergTv.mn

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,746.62	0.29% ▲
Dow Jones	АНУ	26,719.13	2.41% ▲
S&P 500	АНУ	2,950.46	2.20% ▲
Nasdaq	АНУ	8,031.71	3.01% ▲
S&P/TSX	Канад	16,525.43	1.37% ▲
FTSE 100	Их Британи	7,407.50	0.84% ▲
S&P/ASX 200	Австрали	6,650.80	1.48% ▲
Nikkei 225	Япон	21,258.64	0.67% ▲
Hang Seng	Хонг Конг	28,473.71	5.00% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.24
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.13
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.34
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.47
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.46
DBM' 2023	USD	7.250%	104.09
TDBM' 2020	USD	9.375%	103.75

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.400	0.12 ▲
Libor 3M	2.340	-0.06 ▼
Libor 6M	2.220	-0.05 ▼
Libor 1YR	2.200	-0.05 ▼
US 2YR Bond	1.770	-0.10 ▼
US 3YR Bond	1.723	-0.09 ▼
US 5YR Bond	1.789	-0.07 ▼
US 10YR Bond	2.051	-0.05 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.06.21	Өөрчлөлт
USD	2,657.02	0.10% ▲
CNY	386.37	0.79% ▲
EUR	3,005.62	0.32% ▲
RUB	42.10	2.16% ▲
KRW	2.28	1.79% ▲
JPY	24.73	0.82% ▲
CAD	2,014.95	1.26% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,399.63	4.32% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	15.35	3.15% ▲
Зэс	USD/lb.	270.40	2.77% ▲
Нүүрс	USD/MT	72.12	-1.21% ▼
WTI газрын тос	USD/bbl.	57.43	9.37% ▲
Brent газрын тос	USD/bbl.	65.2	5.14% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.19	-8.37% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. V	7.90%
Бодлогын хүү	2019. V	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. V	11.03%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. V	11.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. V	4.93%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. V	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. V	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 42 компанийн 1,034.8 сая төгрөгийн 9,823,614 ширхэг хувьцаа арилжигдав.

“Дархан зочид буудал” /DZG/ компанийн хувьцаа 22.34%-аар буюу хамгийн ихээр өсөж 115.0 төгрөгт хүрч хаагдсан бол “МИК Холдинг” /MIK/ компанийн хувьцаа 15.20%-аар буурч 10,600.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


6-р сарын 21-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,451.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,746.62 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.29%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,034.8
Зах зээлийн үнэлгээ	2,451,270.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,746.62	0.29% ▲
MSE I индекс	8,805.46	-2.83% ▼
MSE II индекс	7,990.13	2.65% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	6,006,668	342,131,541
Ард даатгал	200,239	125,564,700
Ард кредит ББСБ	1,745,232	124,227,620
Инвескор ББСБ	52,623	95,009,830
Монос хүнс	1,184,007	84,371,227

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан зочид буудал	115.00	22.34% ▲
Түмэн шувуут	187.56	15.42% ▲
Хүннү менежмент	212.75	15.00% ▲
Э-транс ложистикс	100.00	13.64% ▲
Би Ди Сек	887.01	8.97% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
МИК Холдинг	10,600.00	-15.20% ▼
Хөх ган	73.60	-9.12% ▼
Мерекс	25.00	-7.41% ▼
Баянгол зочид буудал	27,180.00	-5.95% ▼
Махимпекс	2,500.00	-4.32% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	601,229,753
Ард Секьюритиз	311,196,667
Голомт Капитал	250,567,736
Гаули	214,738,315
Бумбат-Алтай	143,062,412

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	568.00	604,455
Таван толгой	6,900.00	363,390
Говь	287.00	223,892
МИК Холдинг	10,600.00	219,519
Инвескор ББСБ	1,810.00	129,828

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 6-р сарын 20-ны өдрийн 17:00 цагт (Атлантын зуны цагаар) Канад улсын Нова Скошиа мужийн Халифакс хотын Пурдис Варф Тауэрт зохион байгуулагдах бөгөөд хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад зориулан компанийн www.erdene.com вебсайт дээр байрлах вебкастаар дамжуулан хурлын үйл ажиллагааг сонсох боломжийг олгож байгаа тухай мэдэгдлээ.

Хурлаар Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ судалгааны явц, сүүлийн өрөмдлөгийн үр дүн, Хөндий Алтны Дүүрэгт хайгуулын үйл ажиллагааг цаашид өргөжүүлэх боломжууд зэрэг мэдээллүүдийг танилцуулна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Ард даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Ард Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2-р сарын 19-ний өдрийн №2/19 тоот тогтоолоор баталсан ногдол ашгийг 2019 оны 6-р сарын 17-ны өдрөөс эхлэн компанийн төв оффис болон Сэнтрал тауэрт байрлах салбараар дамжуулан хүсэлт гаргаснаар өөрийн дансанд хүлээн авах боломжтой болсон бөгөөд хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг 2019 оны 6-р сарын 28-ны өдрөөс хойш “ҮЦТХТ” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар болсон байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



ЛэндМН: Итгэлцлийн үйлчилгээгээр 4 сая доллар босгоно

МХБ-ийн үнэт цаасны I ангилалд бүртгэлтэй Лэндмн ББСБ /MSE:LEND/ хувьцаат компани СЗХ-ноос Итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан талаар бид өмнө мэдээлж байсан билээ. Тэгвэл, тус компани нь “Мирэ Эссет Секьюритис Монгол” ҮЦК-тай 4 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг “Итгэлцлийн гэрээ”-ээр босгоход хамтран ажиллах санамж бичигт 2019.06.03-ны өдөр гарын үсэг зурлаа. Энэхүү хамтын ажиллагааны эхлэл болж 4-р сард “Мирэ Эссет Секьюритис Монгол” ҮЦК-аар дамжуулан эхний ээлжийн 1 сая ам.долларын санхүүжилтийг БНСУ-ын Райнос Эссет Менежмент болон бусад гадны хөрөнгө оруулагчдаас босгосон талаар компанийн зүгээс мэдээлэв. Энэ үеэр Лэндмн ББСБ /MSE:LEND/-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга “Манай компани 2019 онд өндөр зорилт тавьсан байгаа. Үүнд хүрэхэд бидний хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой” гэж онцолсон. Лэндмн ББСБ /MSE:LEND/-ийн хувьд энэ оны 1-р улиралд 78.9 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчиддаа олгож, 2.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд нэгж хувьцаандаа EPS = 1.56 буюу нийт 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олсон. Харин 2019 онд 6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар компани төлөвлөвд байгаа юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6-р сарын 07-ны өдрийн № А/20 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 7-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2019 оны 7-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт

Хуралдах газар: Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт Хотел энд Конвеншн Центрын “Ивент Холл”-д

Бүртгэлийн өдөр: 2019 оны 7-р сарын 1-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- 2019 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
- Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсөв батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл харилцдаг үнэт цаасны компани болон Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, 14210, Худалдаа, хөгжлийн банкны төв байранд байрлах “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн байранд ирж танилцаж болно.

Холбоо барих утас: 7709-0077.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Говь: Гоёо ХХК-ийг худалдан авахаар боллоо

Говь /MSE:GOV/ компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Гоёо” ХХК-ийг 100% худалдан авах шийдвэр гаргасан байна.

Тодруулбал, Гоёо ХХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 21,056,968 ширхэг энгийн хувьцааг “Таванбогд Трейд” ХХК-аас авч байгаа юм.

Ийнхүү хөрөнгө оруулагчдын дунд өрнөөд байсан нэгдэл албан ёсоор баталгаажив байна.

Эх сурвалж: MarketInfo.mn



Засгийн газрын бондыг ирэх оноос арилжихаар төлөвлөж байна

Засгийн газрын бонд дотоодын хөрөнгийн бирж дээр арилжихаа болиод 2 жилийн нүүрийг үзэж байна.

Хамгийн сүүлд 2017 оны 10 сард хамгийн сүүлийн бондын арилжаа явагдаж байсан бөгөөд 28 долоо хоногийн хугацаатай бондыг арилжсан.

Тэгвэл Сангийн яамнаас ирэх оноос эхлэн бондын арилжааг эхлүүлэхээр төлөвлөж байгаа аж. Ингэхдээ Монголын хөрөнгийн бирж болон блокчэйн технологид суурилсан арилжааг хийх юм байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

СЯ: VI сард цайрын экспортын дундаж ханш тонн тутамдаа 2,746.79 ам.доллар гэж тооцоолсон

6-р сард экспортод гаргаж байгаа эрдэс бүтээгдэхүүнүүдийн дундаж үнэ ханшийг Сангийн яам танилцууллаа.

Энд дурдсанаар цайрын ханш нэг тонн тутамдаа 2,746.79 ам.доллар байна. Цайрын ханш 2018 онд нэлээд савласан ч 2019 онд харьцангуй тогтвортой байна гэж цайрын экспортын 75 хувийг гаргадаг “Цайрт минерал” ХХК таамаглаж байгаа талаар өмнө нь мэдээлсэн юм. Хэдий тийм боловч 2019 онд цайрын ханш 3,050 ам.доллар, 2020 онд 3,075 ам.доллар болох төлөвтэй гэж “Fitch Solutions” таамаглажээ. БНХАУ-ын Засгийн газар дэд бүтцийн төслүүдээ дэмжиж эхэлсэн нь суурь металлуудын эрэлт нэмэгдэхэд нөлөөлнө гэж үзэж байгаа юм байна.

Нэг тонн хар тугалганы зургаадугаар экспортын ханш 1,774.95 ам.доллар гэж Сангийн яам тооцоолжээ. Монгол Улс оны эхний таван сард хийсэн хар тугалганы экспорт 22 хувиар өсөж, 9,468 тонн болсон байна. Гэхдээ мөнгөн дүнгээр 7.3 хувиар өсөж, 95.8 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээлж байлаа.

Харин жоншны тухайд тонн тутамдаа агуулгаасаа хамаараад хайлуур жонш нь 267-324 ам.доллар, жоншны баяжмал нь 416-425 ам.долларын үнэтэй байхаар Сангийн яам тооцоолжээ. Жоншны ханш 2018 оноос сэргэж эхэлсэн юм. Ялангуяа жоншны экспортын 30 гаруй хувийг нийлүүлж байгаа ОХУ-ын зах зээлд энэ нь ажиглагдаж байгаа талаар “Баялаг жонш” ХХК мэдээллээ. 56 хувийн агуулгатай төмрийн хүдрийн зургаадугаар сарын экспортын ханшийг 64.25 ам.доллар, 60 хувийн агууламжтай төмрийн баяжмалыг ханшийг 88.85 ам.доллар гэж тооцсон байна.

Нүүрсний ханшийн тухайд боловсруулаагүй коксжих нүүрсний экспортын үнийг 127.07 ам.доллар, сул коксжих нүүрс 83.02 ам.доллар гэж Сангийн яам тооцжээ. Баяжуулсан коксжих нүүрсний зургаадугаар сарын экспортын үнэ 137.36 ам.доллар, баяжуулсан сул коксжих нүүрс 110.19 ам.доллар гэж тооцсон байна. Энэ онд ханш тогтвортой байх төлөвтэй гэж Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж байгаа МАК компанийн тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Цогт мэдээлж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

АНУ-ын нүүрсний салбарын томоохон 2 компани уурхайнуудаа нэгтгэж, зардлаа хэмнэнэ

АНУ-ын нүүрсний салбарын хамгийн том хоёр компани “Arch Coal” болон “Peabody Energy” хамтарсан үйлдвэр байгуулах замаар зарим уурхайгаа нэгтгэхээр боллоо.

Олон улсын хэмжээнд нүүрсний хэрэглээ хумигдаж, эрэлт татарч байгаа энэ үед хоёр компани зардлаа хэмнэх энэхүү шийдвэрийг гаргаж байна. АНУ-ын Вайоминг болон Колорадо мужууд дахь уурхайнуудын үйл ажиллагааг нэгтгэснээр 820 сая ам.долларын бэлэн мөнгөний хуримтлал үүсгэнэ гэж дээрх хоёр компани хэллээ. АНУ-д Ерөнхийлөгч Дональд Трампын засаг захиргаа нүүрсний салбарыг урьдын хэмжээнд хадгалж үлдэх бодлого барьж байгаа ч эрчим хүчний компаниуд нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудаа хаасаар байна. Оронд нь байгалийн хий, нар, салхины эх үүсвэрийн ашиглалтаа нэмэгдүүлж байгаа юм. 2018 онд АНУ-д нүүрс шатааж гарган авсан эрчим хүчний хэмжээ 6.3 хувиар буурчээ. Нүүрсний уурхайнуудаа нэгтгэнэ гэсэн шинэ мэдээний дараа “Arch Coal”-ийн хувьцааны ханш 8.2 хувиар өссөн бол “Peabody Energy”-ийнх 6.8 хувиар нэмэгджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Барилга Эм Эн: 2030 он гэхэд дотоодын цементийн хэрэглээ ойролцоогоор 3 дахин нэмэгдэнэ

Барилгын материалын 2030 он хүртэлх хэрэгцээг “Барилга.мн” тооцоолон судалсан байна. Барилга, байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх Засгийн газрын зорилтын хүрээнд гол нэрийн дөрвөн материалын үйлдвэрийн төслийг дэмжиж, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг заасан байдаг.

Үүнд барилгын гангийн үйлдвэрлэл, дулаалгын материалын үйлдвэрлэл, угсармал барилгын хийцийн үйлдвэрлэл болон цементийн үйлдвэр багтсан байдаг байна. 2030 он хүртэлх хэрэгцээг задлаад харвал цемент улсын хэмжээнд 2.6 дахин нэмэгдэж, 3.4 сая тонн болох төлөвтэй байгаа ажээ.

Монгол Улсад МАК, “Монцемент БМ” ХХК, “Хөтөлийн цемент” ХХК зэрэг томоохон таван цементийн үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр үйлдвэрүүд нь одоогийн байдлаар дотоодын цементийн хэрэгцээг бүрэн ханган ажиллаж байгаа юм.

Харин улсын хэмжээнд арматурын 12 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт хүчин чадал жилд 80 мянган тонн байгаа ажээ. Энэ нь дотоодын зах зээлийн 20 хувийг эзэлж, 80 хувийг импортоор хангаж байна.

Арматурын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах шаардлагатай. Хэрэв үгүй бол 2030 он хүртэл жилд 300 мянган тонн арматур импортлох чиг хандлагатай байгааг “Барилга.мн” судалгаандаа онцолжээ.

Харин арматурын 2030 он хүртэлх хэрэгцээг харвал суурь үзүүлэлт болох 176 мянган тонноос 454 мянга орчим тонн болж нэмэгдэх төлөвтэй байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Mongolia Energy Corporation” III сараар эцэслэсэн санхүүгийн жилд 776.7 сая хонгконг долларын орлоготой ажиллажээ

2019 оны гуравдугаар сараар эцэслэсэн санхүүгийн жилд “Mongolia Energy Corporation”-ийн орлого өмнөх оноос 21.9 хувиар өсөж, 776.7 сая хонгконг доллар хүрлээ.

Энэ хугацаанд 600 мянга орчим тонн угаасан коксжих нүүрс, 78 мянган тонн дулааны нүүрс борлуулсан байна. Хөшөөтийн ордод үйл ажиллагаа явуулдаг тус компани өнгөрсөн онд нэг тонн коксжих нүүрсийг дундаар 1293 хонгконг доллар, дулааны нүүрсийг 45.3 хонгконг доллароор борлуулжээ.

Нийт ашиг нь бага зэрэг өсөж, 440 сая хонгконг доллар хүрсэн байна. Хэдий тийм боловч нийт ашгийн харьцаа нь 49.5 хувиас 43.2 хувь руу буужээ. Үүнд борлуулалтын зардал өссөн нь голлон нөлөөлсөн байна. Борлуулалтын хэмжээ, тээврийн зардал өссөнөөр зардал мөн нэмэгджээ.

“Mongolia Energy Corporation” олборлолтын ес, хайгуулын хоёр лиценз эзэмшиж байна. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал наймдугаар сарын 27-нд болохоор товлогдоод байгаа юм. Гэхдээ компанийн удирдах зөвлөл өмнөх санхүүгийн жилийн үйл ажиллагаанаас ногдол ашиг тараахгүй байхыг зөвлөсөн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа

Монголбанкны мөнгөний бодлогын хороо ээлжит хурлаараа бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Бодлогын хүүг хэвээр хадгалахад инфляци зорилтот түвшний орчимд тогтворжих хандлага хэвээр байгаа нь голлон нөлөөлжээ.

Монголбанк эдийн засгийн өсөлтийн төсөөллөө шинэчилж танилцууллаа. Тухайлбал, 2019 онд эдийн засаг 7.3 хувиар өснө гэж таамагласан нь өмнөх улирлын таамгаас 0.4 нэгж хувиар өсгөсөн дүн боллоо. Харин 2020 онд эдийн засаг зургаан хувиар өснө гэж Төв банк үзэж байна. Цаашид гадаад худалдааны нөхцөл муудаж болзошгүй байгаа нь уул уурхайн томоохон төсөл хэрэгжиж дуусах, гадаад өрийн том дүнтэй эргэн төлөлт эхлэх хугацаатай давхцаж байна. Тиймээс Засгийн газар, аж ахуйн нэгжүүд санхүүгийн нөөцөө нэмэгдүүлэх шаардлага эн тэргүүнд тавигдаж байгааг онцолсон юм.

Гадаад орчны болзошгүй эрсдэлийг хохирол багатайгаар даван туулж, эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад төсвийн сахилга бат, банкны салбарын эрсдэл даах чадвар, төв банкны бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх нь чухал гэсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монголчуудын худалдан авах чадвар БНАСАУ-тай адил байна

Монгол Улсад сарын дундаж цалин 5-р сарын байдлаар 1,157 мянган төгрөг буюу 436 орчим ам.доллар байна. Энэ нь дэлхийн дунджаас гурав дахин бага гэсэн үг юм. Өнгөрсөн онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага НҮБ-ийн гишүүн орнуудын хэмжээнд сарын дундаж цалинг 1,480 ам.доллараар тооцож байсан юм.

Харин нийт хүн амын тоонд харьцуулсан орлогын хэмжээг тооцвол нэг хүнд ногдох орлого 3,270 орчим ам.доллар байгаа "Worlddata"-ийн судалгаанд дурджээ. Судалгаанд багтсан 80 улсаас Монгол Улс 64 дүгээрт бичигдэж байгаа юм. Өөрөөр хэлбэл Индонезээс бага, Боливаас өндөр гэсэн үг ажээ.

Дотоодын зах зээл дэх хэрэглээний сагсны үнэд харьцуулан тооцдог иргэдийн худалдан авах чадвараар Монгол Улс 137 орноос 112 дугаарт буюу БНАСАУ-ын өмнө бичигдсэн байна.

Монголд ажиллагчдын сарын дундаж нэрлэсэн цалин 2019 оны I улиралд 2010 оны IV улирлаас гурав дахин нэмэгдсэн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлэх бодит цалин ердөө 63.6 хувиар нэмэгджээ.

Байгууллагын төрлөөр нь авч үзвэл Төрийн өмчит үйлдвэрийн газарт дундаж цалин хамгийн өндөр буюу 1,450 мянган төгрөгтэй байгаа бол хоршоодын цалин хамгийн бага буюу 548 мянган төгрөг байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



"Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд 2019 онд 840 сая ам.долларын санхүүжилт орж ирэх хүлээлттэй байна

2017-2018 онд "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Монгол Улсад нэг тэрбум 17 сая ам.долларын санхүүжилтийг Олон Улсын Валютын Сан, донор орнуудаас олгосон байна.

Тухайлбал, Олон Улсын Валютын Сангаас 221 сая ам.доллар, Дэлхийн банкнаас 113 сая ам.доллар, Азийн хөгжлийн банкнаас 400 сая ам.доллар, Япон улсын Засгийн газраас 283.3 сая ам.доллар олгожээ. Хөтөлбөрийн хүрээнд нийт 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийн шугам нээгдэж байсан юм.

Хэдий тийм боловч өнгөрсөн онд орж ирэх санхүүжилтүүд 400 сая ам.доллараар тасарсныг Төв банк мэдээлж байлаа. Харин энэ онд 840 сая ам.долларын санхүүжилтийг авах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 2018 оны 11-р сард "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн зургаа дахь шатны үнэлгээг хийж, ажлын хэсгийн түвшинд мэдэгдэл гаргасан юм. Үнэлгээг Олон Улсын Валютын Сангийн удирдлагаар батлуулсны дараа захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна гэж тухайн үедээ мэдэгдэж байв. Дараагийн санхүүжилтийг авахын тулд хүлээгдэж буй ажлууд үлджээ.

Үүний дараа Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Олон Улсын Валютын Сангийн захирлуудын зөвлөлд Монгол Улсыг төлөөлөн ажиллаж буй Гүйцэтгэх захирал Найжел Рэйг хүлээн авч уулзсан байна.

Уулзалтын үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр үр дүнгээ өгч, амжилттай хэрэгжиж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтэд техникийн шалтгаантай бага зэргийн саатлууд тулгарсан боловч амжилттай шийдвэрлэн цаашид хэвийн үргэлжлэхээр болж байгаа" гэжээ.

Харин Олон Улсын Валютын Сангийн зүгээс "Хүчирхэг банкны салбар, сахилга баттай төсөв, мөнгөний бодлого нь одоо хүрээд байгаа үр дүнгээ баталгаажуулахад чухал" гэсэн байр суурь илэрхийлжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.